

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, "Налайхын дулааны станц" ТӨХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 250 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Налайхын дулааны станц" ТӨХК (Ц.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газрын дарга (Б.Эрдэнэбулган)-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 668, 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 730, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 175 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.....дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт	төг/м ³	3,775.0
		Хэмжүүрээр халаалт	төг/ГЖ	66,082.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан	төг/м ³	11,750.0
			төг/хүн	11,781.0

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.....дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт	төг/м³	1,870.0
		Хэмжүүрээр халаалт	төг/ГЖ	56,170.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан	төг/м³	11,750.0
			төг/хүн	11,781.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна)		төг/м²	1,100.0
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд	төг/хүн	4,888.0
		Халаалтын бус улиралд	төг/хүн	6,843.0
		Усны зарцуулалтаар	төг/м³	8,500.0
4	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх	төг/сар	5,400.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай өрх	төг/сар	9,000.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх	төг/сар	18,000.0